



**МОНГОЛ УЛСЫН
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ**

Засгийн газрын XI байр, Самбуугийн гудамж 11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 33 33,
Цахим шуудан: info@med.gov.mn

2024. 02. 28 № 02/422

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА

Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг,
хөгжлийн сайдын аймаг, нийслэлийн Засаг дарга
нартай байгуулсан 2023 онд хамтран ажиллах гэрээний
хэрэгжилтийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: ... хуудастай.

ДЭД САЙД



Г.ТҮВДЭНДОРЖ

240279

Эдийн засаг, хөгжлийн яамны
2024 оны 02 сарын 28 өдрийн Д.Э./422
тоот албан бичгийн хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД
БОЛОН АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА НАРТАЙ БАЙГУУЛСАН ХАМТРАН
АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА**

Нэг. Зорилго

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Эдийн засаг, хөгжлийн сайдын Засаг дарга нартай байгуулсан гэрээний үүргийн биелэлт болон үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшинд мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Хоёр. Арга зүй

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.2-т заасан аргачлалаар хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Гэрээний зорилго нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэхэд хамтран ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулахад оршиж байгаа бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 1 жилийн хугацаатай байгуулсан.

Гэрээний хоёрдугаар хавсралтад Засаг даргын гүйцэтгэх арга хэмжээг 3 зорилтын хүрээнд тусгасан бөгөөд аймаг тус бүрийн онцлогоос хамааран нэмэлт арга хэмжээг тусгасан байна.

3.1. “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах ажлын хүрээнд” зорилтын хэрэгжилт

Тус зорилтын хүрээнд нийтлэг 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгуудын гэрээнд тусгасан ба Баян-Өлгий, Дорноговь, Сэлэнгэ “Цагааннуур, Замын-Үүд, Алтанбулаг чөлөөт бүсүүдийг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах”, Төв аймагт “Хөшгийн хөндийд шинэ дагуул хот болон эдийн засгийн чөлөөт бүс байгуулахад хамтран ажиллах”, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дорнод, Өмнөговь, Сэлэнгэ, Увс,

Хөвсгөл, Сүхбаатар аймгуудад “хилийн боомтыг хөгжүүлэхэд орон нутгийн зүгээс дэмжлэг үзүүлэх”, “Дундговь аймагт “палеонтологийн нөөцөд тулгуурлан “аялал-судалгаа-амралт”-ын цогцолбор төсөл хэрэгжүүлэхэд орон нутгийн зүгээс хамтран ажиллах” гэх мэт аймаг тус бүрийн онцлогоос хамааран нэмэлт арга хэмжээг тусгасан байна.

Гэрээний 1.1 “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлд хамтран ажиллах арга хэмжээний хэрэгжилт 96.8 хувь, үүнээс Архангай аймаг 50.0 хувийн хэрэгжилттэй буюу арга хэмжээний хэрэгжилтийг хангалтгүй тайлагнасан, хүрэх түвшинд хүрээгүй;

Гэрээний 1.2 Орон нутагт хөрөнгө оруулалт татах, сурталчлах, мэдээлэл харилцан солилцох арга хэмжээний хэрэгжилт 94.5 хувь, үүнээс Хөвсгөл аймаг 30.0 хувь, Сүхбаатар аймаг 70.0 хувийн хэрэгжилттэй тайлагнасан;

Гэрээний 1.3 Хүнсний хангамж, аюулгүй байдлын тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтран төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгаас дэмжлэг үзүүлэх арга хэмжээний хэрэгжилт 91.3 хувь, үүнээс Архангай 30.0 хувь, Орхон аймаг 50.0 хувь, Булган, Сэлэнгэ аймгууд 70.0 хувийн хэрэгжилттэй тайлагнасан;

Гэрээний 1.4 “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр”-ийн төсөлд тусгах саналаа аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, батлагдсан хувилбарыг хүргүүлэх арга хэмжээний биелэлт 96.3 хувь, үүнээс Говь-Алтай аймаг 30.0 хувийн хэрэгжилттэй буюу хүрэх түвшинд хүрээгүй ;

Гэрээний 1.5 Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.9-т заасан “Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө”-ний төслийг тус хуулийн 18.5-т заасан хугацаанд холбогдох хууль, журамд заасан шаардлагуудыг ханган боловсруулж, Эдийн засаг, хөгжлийн яамны саналыг авч, мөн хуулийн 18.6-т заасан хугацаанд батлуулах арга хэмжээ 90.9 хувь, Хэнтий, Дорноговь аймгууд 50.0 хувь, Архангай, Дорнод аймгууд 70.0 хувийн хэрэгжилттэй тайлагнасан;

Гэрээний 1.6 Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг холбогдох журамд заасан хугацаанд ИТХ-аар хэлэлцүүлэн баталгаажуулж, танилцуулгын хамт хүргүүлэх арга хэмжээний хэрэгжилт 89.0 хувь, үүнээс Говь-Алтай аймаг 30.0 хувь, Баян-Өлгий,

Говь-сүмбэр аймгууд 50.0 хувь, Завхан, Сэлэнгэ аймгууд 70.0 хувийн хэрэгжилттэй тайлагнасан;

Гэрээний 1.7 Улаанбаатар хотоос хөдөө, орон нутагт шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих ажлын хүрээнд шилжилт хөдөлгөөн хийсэн иргэд, аж ахуйн нэгжээс судалгаа авах ажлыг зохион байгуулах, судалгааны үр дүнг нэгтгэн улирал бүр Эдийн засаг, хөгжлийн яаманд ирүүлэх арга хэмжээний хэрэгжилт 89.0 хувь, Орхон, Баян-Өлгий, Ховд аймгуудаас бусад аймгууд шалгуур үзүүлэлтэд заасан 4 удаагийн улирал бүрийн тайланг ирүүлээгүй байх бөгөөд хүрэх түвшинд хүрээгүй;

Гэрээний үндсэн зорилт болох хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах хүрээнд дундаж үнэлгээ 171 арга хэмжээ 90.4 хувийн хэрэгжилттэй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, цаашид хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

3.2. “Эдийн засаг, хөгжлийн яамнаас эрхлэн хөтөлж байгаа цахим мэдээллийн санг хөгжүүлэх” зорилтын хэрэгжилт

Тус зорилтын хүрээнд 2 арга хэмжээг гэрээнд тусгасан бөгөөд 21 аймаг, нийслэлээс тайланг ирүүлсэн. Үүнд:

Гэрээний 2.1 Эдийн засаг, хөгжлийн яамны цахим мэдээллийн системүүдийг орон нутгийн холбогдох мэдээллээр тогтмол хангаж ажиллах арга хэмжээний хэрэгжилт дунджаар 100.0 хувь;

Гэрээний 2.2 Орон нутгийн хөгжлийн индекс тооцох цахим системд сумдын хөгжлийн индексийн мэдээллийг 2022 оны байдлаар шинэчилж оруулах; www.idi.nda.gov.mn арга хэмжээний хэрэгжилт дунджаар 100.0 хувиар үнэлэгдсэн.

Эдийн засаг, хөгжлийн яамнаас эрхлэн хөтөлж байгаа цахим мэдээллийн санг хөгжүүлэх зорилтын хүрээнд биелэлт дунджаар 100.0 хувийн үнэлгээтэй, зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан байна.

3.3. “Орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөгч нарыг чадавхжуулах” зорилтын хэрэгжилт

Тус зорилтын хүрээнд 3 арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхээр гэрээнд тусгасан бөгөөд хэрэгжилт дунджаар 98.4 хувийн хэрэгжилттэй байна.

Гэрээний 3.1 Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах сургалтад хөгжлийн бодлого төлөвлөгч нарыг хамруулах арга хэмжээний хэрэгжилтийг 21 аймгаас ирүүлсэн ба дунджаар 97.7 хувьтай байна. Шалгуур үзүүлэлтийг “зохион байгуулсан сургалтын тоо” гэж тогтоосон ч хамааралгүй тайлан бичсэн, Засгийн газраас болон бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдсан зэрэг тайланг ирүүлсэн байна.

Гэрээний 3.2 Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын чиглэлийн хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлгийг хамтран зохион байгуулах, оролцоог хангах арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувийн үнэлгээтэй байна.

Дөрөв. Дүгнэлт

Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдаас аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд гэрээний гуравдугаар хавсралт дахь “хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-ий дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилт дунджаар 96.2 хувь, журмын 6.2.3 заалтын дагуу “арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарсан, хэрэгжилт, үр дүнг сайжруулах шаардлагатай” гэж дүгнэж байна.

Аймаг тус бүрээр хэрэгжилтийг тооцоход, Нийслэл үр дүнтэй буюу 100.0 хувийн хэрэгжилттэй, 21 аймаг 92-98.1 хүртэл хувийн хэрэгжилттэй буюу тодорхой үр дүнд хүрсэн байна.

Хэрэгжилт хангалтгүй үнэлэгдсэн арга хэмжээний хувьд гэрээнд заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн яамтай хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээ, шалгуур үзүүлэлтийн хүрээнд тайлагнаагүй, тайлан дутуу, хэт товчилсон, тодорхойгүй, хүрэх түвшинд хүрээгүй болон өнгөрсөн оны байдлаар хэрэгжилтийг ирүүлсэн байна.

Тав. Цаашид авах арга хэмжээний санал

Гэрээний биелэлтийг ирүүлэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 3.1.4-д заасан “тайлан дүгнэлт нь тухайн бодлого, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг тодорхойлсон, нотлогдохуйц байх” гэсэн зарчмыг баримтлан баримт материалыг хавсаргаж байх, тайланг шалгуур үзүүлэлтийн дагуу тодорхой, иж бүрэн өгөхөд анхаарч ажиллах;

- Гэрээний шалгуур үзүүлэлтийн суурь түвшний мэдээллийг бүрэн гүйцэд тусгаж, хүрэх түвшний дагуу тоон болон чанарын үзүүлэлтээр тодорхой тайлагнах;

- Гэрээний хэрэгжилтийг тайлагнахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг тусгахгүй байх нийтлэг дутагдал илэрч байгаа тул хамт тайлагнаж хэвших;

- Төлөвлөсөн хугацаандаа хийгдээгүй ажлуудад тайлбар ирүүлж байх;

- Гэрээнд заасан “Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг холбогдох журамд заасан хугацаанд ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж, танилцуулгын хамт хүргүүлэх” арга хэмжээний хувьд хэрэгжилтийн тайланг дараа оны 3 дугаар сарын 01-ний дотор Эдийн засаг, хөгжлийн яаманд ирүүлэхээр журамд заасан тул гэрээнд тусгахдаа хяналт-шинжилгээ, үнэлгээний журамтай уялдуулах.

Хүснэгт 1. Аймаг, нийслэлийн дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн хувь, арга хэмжээ тус бүрээр

Нэр	Арга хэмжээ - 1										Арга хэмжээ - 2			Арга хэмжээ - 3			Арга хэмжээ үнэлгээ	Үнэлгээний дундаж				
	1.1	1.2	1.3	1.4	1.5	1.6	1.7	1.8	1.9	1.10	Арга хэмжээ - 1			Арга хэмжээ - 2					Арга хэмжээ - 3			
											хэмжээ - 1	үнэлгээ	үнэлгээ	2.1	2.2	2.3			2.4	3.1	3.2	3.3
Архангай	50	90	30	100	70	100	100	100	50		76.7	100	100				100.0	100	100		100.0	92.2
Баян-Өлгий	100	100	100	100	100	50	100	100	100		94.4	100	100				100.0	100	100		100.0	98.1
Баянхонгор	100	100	100	100	100	100	100	50			93.8	100	100				100.0	100	100		100.0	97.9
Булган	90	100	70	100	90	100	100	50	50.0		85.0	100	100				100.0	100	100		100.0	95.0
Говь-Алтай	100	90	100	30	100	30	100	90			80.0	100	100				100.0	100	100		100.0	93.3
Говь-сүмбэр	100	100	100	100	100	50					91.7	100	100				100.0	100	100		100.0	97.2
Дархан-Уул	100	100	100	100	100	100	50				92.9	100	100				100.0	100	100		100.0	97.6
Дорноговь	100	100	100	100	50	100	100	50			87.5	100	100				100.0	100	100		100.0	95.8
Дорнод	100	100	100	100	70	100	100	50			90.0	100	100				100.0	100	100		100.0	96.7
Дундговь	100	100	100	100	100	100	100	50			93.8	100	100				100.0	100	100		100.0	97.9
Завхан	100	100	100	100	100	70	100	100			96.3	100	100	100	100		100.0	50	100	100	83.3	93.2
Нийслэл	100	100	100	100	100	100					100.0	100	100				100.0	100	100		100.0	100.0

Орхон	90	100	100	50	100	100	100	100	100	100	100	100	100	100	100.0	100	100.0	97.1	
Өвөрхангай	100	100	100	100	100	100	100	50	100	100	100	100	100	100	100.0	50	83.3	92.0	
Өмнөговь	100	100	100	100	100	100	100	50	100	100	100	100	100	100	100.0	100	100.0	97.6	
Сүхбаатар	100	70	100	100	100	100	100	30	100	100	100	100	100	100	100.0	100	100.0	95.2	
Сэлэнгэ	100	100	100	70	100	100	100	50	100	100	100	100	100	100	100.0	100	100.0	95.9	
Төв	100	100	100	100	100	100	100	50	100	100	100	100	100	100	100.0	100	100.0	97.9	
Увс	100	100	100	100	100	100	100	50	100	100	100	100	100	100	100.0	100	100.0	97.9	
Ховд	100	100	100	100	90	100	100	90	100	100	100	100	100	100	100.0	100	100.0	97.9	
Хөвсгөл	100	30	100	90	100	100	100	50	100	100	100	100	100	100	100.0	100	100.0	94.6	
Хэнтий	100	100	100	100	100	100	100	90	100	100	100	100	100	100	100.0	100	100.0	97.5	
Үнэлгээний дундаж	96.8	94.5	91.	3	96.	90.	89.	89.	71.	75.	50.0	90.47	100	100	100.0	97.	100	98.4	96.2

-----00000000-----